

ОРЧИН ҮЕИЙН ДАЙН, ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНД НИЙГЭМ, ОЛОН НИЙТИЙН ХАНДАХ ХАНДЛАГА, СУРГАМЖ ДҮГНЭЛТ

Ч. Эрдэнэчулуун
Социологийн ухааны доктор

Abstract: In the article, Russia, which approaches the international arena from different positions, considers the war in Ukraine and the political, social, and cultural factors surrounding it from the point of view of military sociology. It also discusses the position of Russia's neighboring countries, public attitudes, and lessons learned from the war.

Keywords; war, social & cultural, military sociology, public attitudes

Цэргийн социологи нийгэм-улс төрийн онцгой үзэгдэл болох дайны хувьсал болон орчин үеийн дайн, зэвсэгт мөргөлдөөний судалгааг **хоёр үндсэн** зорилготой хийж иржээ.

Нэгдүгээрт: анагаах ухаан хүн төрөлхтнийг хамгийн хүнд өвчин эмгэгээс ангижруулахын тулд судалдаг бас эмчилдэгтэй адил социологийн шинжлэх ухаан дайн зэвсэгт мөргөлдөөний шалтгааныг гүн гүнзгий судалгааны үндсэн дээр танин мэдэх хүн төрөлхтөн амар тайван ажиллаж, амьдрах туйлын чин зорилгын үүднээс дайн, зэвсэгт мөргөлдөөнийг учир шалтгааныг судалж танин мэдсэний үндсэн дээр улмаар түүнээс юун түүрүүнд урьдчилан сэргийлэх, саармагжуулах, аль болох гаргуулахгүй байх олон улсад нэгэнт тогтсон дэг журам, эрх зүйн хүрээнд шийдвэрлэж таслан зогсооход чиглэгддэг;

Хоёрдугаарт, дайн болж байгаа юм уу, гарах боломж бий болж байгаа л бол улс орныхоо аюулгүй байдлыг хангах асуудлыг бүс нутгийн болон дэлхийн хэмжээнд илүү үр дүнтэй яриа хэлэлцээгээр шийдвэрлэхийн тулд тэдгээрийн хууль зүй тогтол, шинж чанар, өөрчлөлт хандлагыг сайтар судалж мэдэх, тэр тусмаа түүнээс урьдчилан сэргийлэх, аюул, занал заналхийллээс зайлсхийх нэгэнт бий болсон олон улсын эрх зүйн чадамжийг бүх талаар ашигласан эсэх зэрэг.

Олон улсын харилцаа, аюулгүй байдалд гарч буй өөрчлөлт хандлага: Олон улсын харилцаа маш олон хувилбараар өрнөж, хэлж таашгүй, урьдчилан харж чадашгүй нөхцөл байдлыг бий болгож байна, Орчин үеийн олон улсын аюулгүй байдлын нөхцөл байдал өөрчлөгдлөө, Олон улсын харилцааны тогтсон дэг журам эвдэгдэж байна, Даяаршиж буй дэлхий дахинд шинэ шинэ олон аюул, занал, заналхийлэл бий болж байна, Геополитикийн эрх ашиг сонирхлын зөрчил нэмэгдсэн, Эрдэс баялаг, эрчим хүчний нөөцийн өрсөлдөөн даамжирч байна, Дэлхий нийтийг хамарсан хямрал, халдварт өвчин, байгаль цаг уурын өөрчлөлт зэрэг гамшигт өртөх магадлал ихэсч байна, Дайн, зэвсэгт мөргөлдөөний улмаас нөхөгдөшгүй асар их хохирол сүйрэл учирч байна, Бүс нутгийн харилцааны нөхцөл байдал ч тийм таатай биш байна, Монгол Улсын гадаад харилцаа биднээс шалтгаалсан болон үл шалтгаалсан амаргүй нөхцөлд байна, Орос, Украины асуудлаас үүдсэн хүнсний хомсдол дэлхийд нүүрлэж байгаа зэргийг нэрлэж болно.


Хөрш болон бусад орны харилцаа, аюулгүй байдлын эргэн тойронд болж өнгөрсөн үйл явдлаас сургамж авч дүгнэлт хийх нь бидний хувьд хамгийн зөв гарц. Тийм учир ойрмогхон хөрш оронд болж өнгөрсөн болж байгаа хэд хэдэн үйл явдлын цаг хугацааных нь дарааллаар санал бодлоо дор илэрхийлж байна.

Бидний мөнхийн хөрш Орос –Украины болон Төв Азийн тусгаар тогтносон Казахстан, Кыргызстанд болж өнгөрсөн өрнөж байгаа үйл явдлыг үндэсний эв нэгдэл, ёс суртахуун, нийгмийн сэтгэл зүй, үнэт зүйлс, шударга ёсны зэрэг социологийн судалгааны үндсэн асуудал болох нийгмийн социал харилцааны талаас нь бид шууд утгаар нь биш ч дам утгаар нь өөрсөдтэйгөө харьцуулан эргэн харж ухаарах, анхаарал хандуулж, сургамж болох утгаар нь судлах шаардлагатай.

Казахстан, Кыргызстанд улсад болсон үйл явдлыг өгүүлэн буй сэдэвт хамаарах агуулгаар нь авч үзвэл: гадаад дотоод хүчин зүйл мэдээж нөлөөлсөн байж таарах ч засаглалын легитим шинж суларсан, дотоодод болж байгаа улс төр, эдийн засаг, нийгэм, оюун санааны сөрөг хандлагыг тухай бүрд нь төр засгийн байгуулга, албан тушаалтан анхаарч шийдэхгүй цаг алдсан, засаглал нь нэг нам, нэг хүний гарт хэт удаан хугацаагаар төвлөрсөн, нийгмийн харилцаанд нь авлигал хээл хахууль хавтгайрсан, албан тушаалд нам, танил тал харж томилдог, хувийн эрх ашгаа улсын эрх ашгаас

илүүд бодсон, бодлого үйл ажиллагаа нь нийгэм олон нийтдээ ил тод бус, шударга ёс алдагдсан, орлогын тэгш бус хуваарилалт, нийгмийн нэг хэсэг нь хууль бусаар хэт баяжиж байхад нийгмийн нөгөө нэг хэсэг нь хэт ядуурсан, овог хоорондын болон шашин хоорондын зөрчил мөргөлдөөн зэргийг товч дурдаж болохоор байна.

Оросын хөрш орнуудын байр суурь. (нийгэм, олон нийтийн хандах хандлага)²⁰



Оросын хөрш орнуудын НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хуралдаанд өгсөн санал²¹

№	Улс	Байр суурь
1	Умард Солонгос	Дэмжсэн /2/
2	Беларус	
3	Хятад	Түдгэлзсэн /7/
4	Казахстан	
5	Азербайжан	
6	Гүрж	
7	Монгол	
8	Финланд /НАТО-д элсэх өргөдлөө мэдүүлсэн/	
9	Турк	
10	Украин	Эсэргүүцсэн /10/
11	Латви	
12	Эстон	
13	Норвеги	
14	Литва	
15	Польш	
16	АНУ	
17		
18	Дани	
19	Япон	

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн онц тусгай чуулганд Орос-Украины хямралын асуудлаар санал хураалт явуулахад Монгол улс түдгэлзсэн.

Энэ бол Монгол Улсын гадаад бодлогын тулгуур баримт бичигтээ Монгол Улс энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого явуулна гэсэн заалтаа баримталсан гэсэн үг²². Энэ бол Монгол улсын, нийгэм, олон нийтийн албан ёсны байр суурь

Мэдээж таатай бус нөлөө үзүүлнэ. Энэ дайн даян дэлхийд сөргөөр нөлөөлнө, нөлөөлж ч байна. Орос оронд бүр ч халтай тусч байна. Орос орон бүрэн ганцаардсан нөхцөлд дайнаа үргэлжлүүлж байна.

Орос-Украины дайны сургамж, дүгнэлт

Орос - Украины дайн сунжрах тусам цаашдын өрнөл улам бүрхэг болж байна. Тухайлбал, Афганистаны дайн шиг их гүрнүүдийн цэрэг, дайны туршилтын талбар, хууль бус зэвсэгт бүлэглэл,

²⁰ www.iss.gov.mn

²¹ СБ ООН проголсовал за проведение сессии Ген ассамблеи по Украине <https://www.interfax.ru/world/825018>

²² Гадаад бодлогын бодлогын үзэл баримтлал 1994

иргэний дайны байдалтай нийгэм, эдийн засгийн хувьд тогтворгүй байдал Украинд бий болох магадлалтай.

Өрнөдийн улс орнууд зэвсэг техник, санхүү, эдийн засгийн ихээхэн дэмжлэг үзүүлж байгаа боловч, Киевт улс төржсөн, авлигад идэгдсэн “муу засаглал” хэвээр үргэлжилбэл нөхцөл байдал дээрдэхгүй. Дээрх үйл явцыг ажиглавал гурван чухал сургамжийг тэмдэглэх хэрэгтэй хэмээн үзэж байна²³.

Хэт улс төржилтөөс зайлсхийх. Үндэс угсаа нэгт Орос, Украин улсууд олон зуун жилээр хил залгаа оршин Баруун болон Төв Европыг Евроазийн зах зээлтэй холбож эдийн засгийн харилцан ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлэх боломжтой байв.

Гэвч Украины улс төрчид эрх мэдэл, ашиг хонжооны төлөө сонгуулийн тогтолцоог ашиглан булаалдаж, улмаар гадаад бодлого болон үндэстэн, угсаатны асуудлыг улс төржүүлэх болов. Үүний үр дүнд дотоодын эв нэгдэл үгүй болж, гаднын тоглогч нарын “олз” болсон.

Авлига газар авах. Украины эрх баригчид авлигад автаж хавтгайрсан нь улс төрийн эрх мэдэлд хүрэх зорилгоор авлигыг тэтгэн, дэмжиж засаглалын чадавхыг сулруулан ард түмний улс төрчдөд итгэх итгэлийг алдагдуулж байна.

Үүний үр дүнд гадаадын тусгай албад ялангуяа, Оросын зүгээс улс төрчдийг эдийн засгийн ашиг сонирхлоор нь барьцаалах боломжийг бүрдүүлсэн. Хэт их улс төржилт, авлигын улмаас төрийн албаны тогтолцоо, ялангуяа аюулгүй байдал болон хууль сахиулах байгууллагын хүчин чадавх эрс муудсан.

Барууны зээл тусламжийг шамшигдуулах, Оросын байгалийн хий зэрэг эдийн засгийн төслийн хөрөнгө, мөнгө завших асуудал зөвхөн сонгуулийн үед хөндөгдөөд өнгөрдөг болсон байна.

Үндэсний эв нэгдэл алдагдах. Хүн амын дунд орос иргэдийн хавчин гадуурхах, тэдгээрийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг сайжруулах талаар дорвитой арга хэмжээ авахгүйгээр барахгүй хэт үндэсрхэг үзэлтнүүдийн хэрцгий үйлдлийг төр засгаас таслан зогсоож чадаагүй

Энэ нь нэг талаас орос иргэдийн гомдол, бухимдал, өшөө хорслыг нэмэгдүүлэх, нөгөө талаас хилийн чанад дахь орос үндэстэн, иргэдээ хамгаалах зорилгоор Оросын зүгээс ил далд тусгай ажиллагаа явуулах боломж олгосон хэмээн үзэж байна.

Тодруулбал, геостратегийн ач холбогдол бүхий Крымиг нэгтгэн авах, цаашлаад Украины эсрэг дайн өдөөхөд томоохон шалтаг болжээ.

ОХУ-Украины дайны асуудлаарх улс орнуудын засгийн газар, нийгэм, олон нийтийн хатуу байр сууриа хадгалахад хүндрэл учруулж болзошгүй **гурван сорилт ажиглагдаж байна.** Үүнд:

Нэгдүгээрт, цаг хугацааны явцад Украины дайныг улс орон, олон нийт сонирхох нь буурч магадгүй юм. Үнэхээр ч улс орон, олон нийтийн анхаарал буурах шинж тэмдэг аль хэдийн илрээд эхэлжээ.

Хоёрдугаарт, ОХУ-д тавьсан хориг арга хэмжээний эдийн засгийн хохирол ирэх саруудад улс орнууд, нийгэм, олон нийтэд улам бүр мэдрэгдэх болно. Тэр дундаа зуны халуун улирал, удахгүй намрын сэрүүн эхэлж эрчим хүчний үнэ нэмэгдэж, хангамжийн талаарх хэрэглэгчийн бухимдал улам нэмэгдэнэ.

Гуравдугаарт, Хүчний тэнцвэрийн харьцааг хувааж өөрчлөх гэсэн нэгэнт тогтсон нэг талын олон жилийн харилцааны ноёрхол улам бүр даамжирч дэлхийн олон орны улс төр эдийн засгийг сүйрүүлж, зогсонги байсан хүйтэн дайныг улам бүр гааруулах, дайныг улам бүр сунжруулах вий гэсэн болгоомжлол ч дагалдаж байна

Нийгэм, олон нийтийн санаа бодол гэдэг яаж ч өөрчлөгдөж болно. Нийгэм олон нийтийн санаа бодол өөрсдөд нь хэдийд тааламжтай бус нөхцөл байдал мэдрэгдэнэ төдийд л өөрчлөгддөг зүй тогтолтой гэмээр нийгмийн сэтгэл зүйн харилцааны далд хууль үйлчилдгийг социологичид андахгүй.

Тиймээс олны байр суурийг тогтвортой байлгахын тулд улс орнуудын засгийн газрын хатуу хориг арга хэмжээ нь “Монголчуудын ярьдгаар өөдөө хаясан чулуу өөрийн толгой дээр гэдэг шиг” Украины ард түмний төлөө бус, мөдхөн өөр өөрийнх нь иргэдийн ашиг сонирхолд нийцэж буйг тайлбарлах учиртай байж мэдэхээр болоод байна.

Бид нийгэм, олон нийт энэ бүхнээс ямар сургамж дүгнэлт хийж болох вэ?

Дараах асуудлыг урт хугацааны стратеги, нэгдсэн бодлого, үйл ажиллагаанд зангидаж шийдвэрлэх нь зүйтэй хэмээн үзэж байна. Энэ бол бидний бусдаас авах сургамж, дүгнэлт байх болно.

²³ www.iss.gov.mn

Хоёр хөршөөс стратегийн хэт хамаарлыг арилгах - хэдийгээр хөрш хоёр улсаас эдийн засаг, бараа, материалын хамааралтай боловч, энэ хамаарлыг багасгах, ялангуяа, стратегийн ач холбогдол бүхий түүхий эд /ШТМ/-ийн нөөц бүрдүүлэх, дотооддоо боловсруулах, дэд бүтцийн хувьд олон улстай холбох гарц, гаргалгааг бий болгох, тэдгээр салбарыг дотоодын улс төр, бизнесийн бүлэглэлийн оролцооноос ангид байлгах цогц арга хэмжээ авах.

Судалгаа, мэдээллийн бүтцийг бэхжүүлэх - Оросын зүгээс баруун тийш чиглэсэн геополитикийн бодлого, үйл ажиллагаа 2005 оноос хойш эрчимжсэн боловч, тус бүс нутгийн ихэнх улс орнууд Оросын цэрэг-улс төрийн үйл ажиллагааны талаар мэдээлэл, судалгаа тааруухан байсан нь энэ дайны явцаас харагдаж болно.

Иймд эдийн засгийн хувьд эмзэг Монгол улс бидний хувьд хоёр хөршийн геополитикийн бодлого, улс төр, нийгэм, эдийн засгийн байдлыг гүнзгий судалж, тэр дундаа эдийн засгийн хувьд бие даах гарц, гаргалгаа боломжийг байнга эрэлхийлэх.

Гадаад харилцааг хүчирхэгжүүлэх - жижиг улсын хувьд гадаад харилцаанд баримтлах бодлогыг улс төржүүлэхгүй, мэргэжлийн боловсон хүчнээр бэхжүүлэх, НҮБ болон олон улсын байгууллагын хүрээнд идэвхтэй ажиллах, мөн нөлөө бүхий улс орнуудад суугаа дипломат төлөөлөгчдийн газрыг хүн хүч, санхүүжилтээр хангаж, тухайн улс орнуудтай бүх шатанд зөвлөлдөх механизмыг бий болгож, үйл ажиллагааг тогтмолжуулах.

Иргэдийн үг хэлэх эрх чөлөөг хүндэтгэх - Оросын нөлөөний бүсэд байгаа аюулгүй байдал, эдийн засгийн хувьд хэт хамааралтай, голдуу авторитар дэглэмтэй улс орнууд дайны эсэргүүцэн Украины дэмжсэн жагсаал цуглаан, үзэл бодлыг хязгаарлаж байна.

Гэсэн хэдий ч Казахстан, Гүрж зэрэг улсуудад төр засгийн удирдлагын түвшинд Орос-Украины асуудлаар “түдгэлзсэн” байр суурь баримталж, иргэдийн дуу хоолойг хүндэтгэн хязгаарлалт хийгээгүй байна.

Монгол улсын хувьд иргэд Үндсэн хуулиар олгогдсон эрхийн дагуу тайван замаар үзэл бодлоо илэрхийлж байгаа боловч, тэдний үйл ажиллагааг хязгаарлах, дарамт шахалт үзүүлэх орчинг бүрдүүлсэн нь олон улсын түвшинд тааруухан харагдуулах болсон.

Монгол улсын хувьд ЗХУ-ын үед Украин иргэд ихээр амьдарч байсан, Украинд сурч, амьдарч байсан зэрэг бүх талын хамтын ажиллагаатай байсны хувьд иргэдийн дуу хоолойг нээлттэй байлгах.

Гадаадад байгаа иргэдээ дэмжих, холбоотой байх - Украины нөхцөл байдал хүндрэхэд тус улсаас гадаадад оршин суугаа иргэд олон улсын түвшинд хийгээд тухайн улс орныхоо улс төр, эдийн засаг, хүмүүнлэгийн дэмжлэг авахад чухал үүрэгтэй болох нь харагдлаа.

Иймд Монгол улсын хувьд гадаад улс орнуудад байгаа монгол иргэдийг дэмжих, тэдэнтэй хамтран ажиллах, зохион байгуулалтад оруулах бодлогыг боловсруулж, холбогдох яам, агентлагт тодорхой нэгж байгуулан улс төржүүлэхгүй, дотоодын улс төрийн нөхцөл байдлын өөрчлөлтөөс ангид байлгах шаардлага тулгарч байна.

Монгол улсын хувьд сонгуульд оролцож байгаа улс төрийн нам, эвслүүд хэт улс төржихөөс зайлсхийх, ялангуяа, үндэсний эв нэгдэл, гадаад бодлогын асуудлаар улс төржихгүй байх нь тун чухал байна.

Авлигаас бүрэн ангижирч чадахгүй нь тодорхой боловч, авлигын хүрээг хумих, авлигатай тэмцэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай. Авлигатай тэмцэх үйл хэргийг улс орны тусгаар тогтнолын “дархлаа” хэмээн ойлгох учиртай.

Үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, ялангуяа үндэстэн, ястнаар хуваагдан зөрчилдөх асуудлыг ул суурьтай судалж, урт хугацааны бодлого боловсруулах, “хэт үндсэрхэг” үзэлтэй иргэд, төрийн бус байгууллагын болон шашны үйл ажиллагааг хязгаарлах, хууль зөрчсөн тохиолдолд зохих шийтгэл ноогдуулах нь зүйтэй

Шашин бол нийгмийн харилцаа, оюун санаанд сайн болоод саар талаар нөлөөлдөг нэг хүчтэй хүчин зүйл төдийгүй бас дайн зэвсэг мөргөлдөөний нэг үндсэн шалтаг шалтгаан болж ирснийг хүн төрөлхтний эрт, эдүгээгийн түүх бэлхнээ харуулдгийг бид мэднэ. Уламжлалт буддын шашны сүм хийдийн нэгдсэн бодлого, үйл ажиллагаа хараахан цэгцэрч чадаагүй байна. Харин буддын шашин нийгмийн оюун санаанд эзлэх байр сууриа харийн бусад шашинд аажим аажмаар алдаж байна.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа шашныг гарал үүсэл, номлол сургаалын агуулга, нийтлэг шинжээр ангилж авч үзвэл: христийн шашны гаралтай шинэ шашин, буддын шашны болон хиндиузмын гаралтай шинэ шашин, бөө мөргөл, тэнгэр шүтлэгийн гаралтай шинэ шашин, шашны

янз бүрийн сургаал номлолын гаралтай нийлмэл шашны урсгал, хөдөлгөөн зэргийг нэрлэж болох байна. Түүнчлэн Монгол Улсад гадаадын зарим улс оронд хориглож, хязгаарласан, гаднын судлаачдын зүгээс гаж буруу, нийгэмд хор хөнөөлтэй гэж зарласан шашны хөдөлгөөн байгаа нь нийгмийн оюун санаа, үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого үйл ажиллагааны хүрээнд онцгой анхаарах асуудал мөн²⁴.

Тэдгээрийн харилцааг зохицуулсан шинэ хуулийн заалт, журам нэн шаардлагатай байна. Мөн газрын хуультай эн дүйцэх Төр сүм хийдийн харилцааны тухай хуулиа ч эргэн харж шинэчлэх шаардлага байна.

Харь орны аж төрөх ажил амьдралын хэв маягийг бодлогогүй хуулбарлах нь ихэд осолтойг бидний болоод гадаадынхны сүүлийн жилүүдийн гашуун боловч түүх харуулж байна. Барууны соёл иргэншил монголчуудын уламжлалт ёс суртахууныг машид их бүдгэрүүлж байгааг анхаарахгүй өнгөрч болохгүй. Өмнөх уламжлалт өв соёл уламжлалаа үгүйсгэх бүхнийг шинээр эхлэх гэсэн оролдлого бүтэл муутайг бид харж байна.

Энэ бүхэн бол улс орны үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнол нийгмийн оюун санаа, үндэсний язгуурын соёл иргэншилд сөрөг нөлөөлөхүйц үзэгдэл үйл явц тул төр, засгийн газар, байгууллага, иргэн бүр онцгой сэрэмжлэх ёстой асуудал мөн.

Монгол Улс газар зүйн байрлалын хувьд Ази тив дэхь гео стратегийн гол төв цэгт, их гүрнүүдийн улс төр, эдийн засаг, соёл иргэншлийн ашиг сонирхлын геополитикийн уулзварт, дэлхийн шашны урсгалын нөлөөллийн бүсэд оршдог өвөрмөц онцлогийг ямагт харгалзаж байх ёстой.

Монгол Улсад гадаад талаас шууд учрах аюул, занал, заналхийлэл үгүй, аюулгүй амар тайван орчин, олон улсын харилцаанд нэгэнт тогтсон харилцан эрх тэгш, олон улсын эрх зүйн таатай орчин, дэг журамд оршин тогтнон, хөгжиж байна.

Гэхдээ энэ нь Монгол Улсын аюулгүй байдлын гадаад, дотоод орчны аюулгүй байдал бүрэн хангагдсан гэсэн үг, үйлдэл хараахан биш хэдий ч харин даяаршин өөрчлөгдөж буй дэлхий ертөнцийн гадаад дотоод шинэ нөхцөл байдал санаанд оромгүйгээр нийгэм, олон нийтийн санаа бодолд улмаар үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх шинэ шинэ хүчин зүйл бий болж байгааг анхаарахгүй өнгөрч хэрхэвч болохгүй.

Монгол Улсын гадаад, дотоод бодлогын хувьд аюулгүй байдлаа хангахдаа улс төр, дипломатын бодлого, үйл ажиллагаа бидний хувьд тэргүүлэх ач холбогдолтой болох нь олон улсын харилцааны өнөөгийн ээдрээтэй нөхцөл байдлын үйл явцаас улам бүр тод харагдаж байна.

²⁴ Алтайбаатар. Ж. Монгол дахь шашнууд: үндэсний аюулгүй байдлын шинэ сорилт, Монгол улсын үндэсний аюулгүй байдал, Хүн амын оюуны дархлааны асуудал Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2022. он.49 дэх тал.